



## ОЮУТНЫ СУРАЛЦАХУЙГ СУДАЛГААНД СУУРИЛСАН БҮТЭЭЛЧ ДААЛГАВРААР ДЭМЖИХ БОЛОМЖ (Багшийн сургуулийн 2 дугаар курсийн оюутнуудын жишээн дээр)

Д.Ганболд<sup>а</sup>, Б.Булган<sup>б</sup><sup>а</sup>МУБИС-Багшийн сургууль, багш, доктор;<sup>б</sup>МУБИС-Багшийн сургууль, багш, докторХолбоо барих зохиогч: ganbold.d@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.08.25

Хянагдсан: 2025.09.25

Зөвшөөрсөн: 2025.11.05

### Хураангуй

Энэхүү судалгаа нь Багш бэлтгэх сургуулийн оюутнуудын суралцахуй-багшлахуйн үнэлгээ, судалгааны арга зүйд суралцаж буй байдал, мэдээлэлд боловсруулалт хийх чадварыг онцолсон болно. МУБИС-ийн Багшийн сургуулийн “Багш мэргэжлийн удиртгал”, “Хичээнгүй бичиг” хичээлийн хөтөлбөрийг судалсан 180 оюутныг хамрууллаа. Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд суурилсан бие даалт нь суралцахуй болон мэдээлэл боловсруулах чадварыг хөгжүүлдэг болохыг баталж байна. Оюутны бүтээлч даалгавар, бие даалтын удирдамжийг боловсруулахдаа “Суралцахуйн төлөвлөлт”, “Аяллын дараах судалгаа”, “Удирдамжтай ярилцлага”, “Хошин зурган ppt”, “Багш, сурагчийн үйл ажиллагааны зураглал”, “Кейс+Зөвлөмж” зэрэг судалгааны аргыг хэрэглэсэн нь тэдний суралцахуйд суралцах болон мэдээлэл боловсруулах чадварыг хөгжүүлдэг болохыг харуулж байна.

### Түлхүүр үг

сурахуйд суралцах, мэдээлэл боловсруулах, судалгааны арга зүй, судалгаа, сургалтын шинэ арга зүй-стратегийн, өөрийн удирдлагатай суралцах

### Удиртгал

Оюутнуудын өөрийн сурах үйл болон багшлахуйн үнэлгээг судалж, судалгааны арга зүйд суралцуулах замаар тэдний мэдээллийг боловсруулах чадварыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага үүсээд байна. Дээд боловсрол нь мэргэжлийн ур чадвар эзэмших, эрдэм шинжилгээ судалгаанд оролцох үндэс суурь болдог бөгөөд эдгээр чадваруудыг оюутнуудад эзэмшүүлэхэд судалгаанд суурилсан бие даалт чухал ач холбогдолтой.

Оюутнууд цахим материалыг ойлгох, мэдээлэл боловсруулах ур чадвар дутмаг байдаг. Дижитал мэдээллийн сан нь оюутныг мэдээлэл боловсруулах ур чадвар руу шилжүүлсэн. Иймд мэдээллийн үнэн зөв, найдвартай байдалд дүн шинжилгээ хийж, мэдээлэлд шүүмжлэлтэй ханддаг байх шаардлагатай (Grafstein, 2002). Оюутны мэдээлэл боловсруулах чадварын хөгжлийг номын сангийн үйлчилгээ нөхөж байдаг. Иймд хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар судалгааны ажил унших даалгаврыг төлөвлөгөөний дагуу өгч байх нь ач холбогдолтой (Winter, 2010). Оюутны бие даалт нь тухайн салбарын эрдэмтэн судлаачдын эх сурвалжийг ашиглах, асуудал шийдвэрлэх, нотлох баримт цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдэлд хүрэх арга замыг санал болгох замаар тухайн сэдвийг судлах үйл явц юм. Сурах арга барилыг судлах нь оюутнуудын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээг хангах, илүү сонирхолтой сургалтын орчныг бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Дээд боловсрол бол ирээдүйн эрдэм шинжилгээний ажлын болон мэргэжлийн эрэл хайгуулын үндэс суурийг тавих чухал үе шат юм. Дээд боловсрол дахь суралцахуйн арга барил нь хөтөлбөрийн үр дүнд чухал нөлөөг үзүүлж байдаг (Biggs, 2011). Идэвхтэй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, оюутнуудын судалгаа хийх арга барилыг хөгжүүлэхийн тулд сургалтын шинэлэг загвар, заах стратегийг судалж, хэрэгжүүлэх үйл явц дэлхийн их сургуулиудад амжилттай хэрэгжиж байна. Гэсэн хэдий ч олон улс орны боловсролын байгууллагууд оюутнуудын үр дүнтэй оролцоог хөгжүүлдэггүй, уламжлалт заах арга барилд тулгуурладаг, ялангуяа практик сургалтаас онолыг илүүд үздэг хандлага ноёлж байна (Nadelson, 2017).

## Судалгааны арга зүй

Судалгааны асуулга, даалгавар

Хүснэгт 1. Судалгааны асуулга, даалгавар

Код.домайн	Домайн	Код.даалгавар	Асуулга/Даалгавар
Д1.1-Д2.1	Шинэ ур чадвар ба судалгааны арга зүйд суралцсан байдал	Д1.1.1-Д2.1.1	Шинэ зууны оюуны зайлшгүй эзэмших ур чадвар
		Д1.1.2-Д2.1.2	Оюутны өөртөө чадвар болгон төлөвшүүлсэн судалгааны арга
Д1.2-Д2.2	Суралцахуй багшийн үнэлгээ	Д1.2.1-Д2.2.1	Өөрийн суралцахуй
		Д1.2.2-Д2.2.2	Багш нарын арга зүй
Д1.3-Д2.3	Судалгааны ёс зүй, арга зүйг эзэмшсэн байдал	Д1.3.1-Д2.3.1	Судлаач оюутанд байх ёстой соёл
		Д1.3.2-Д2.3.2	Судалгааны арга зүйд суралцаж байгаа, түүнийг хөгжүүлэх шаардлага

*Д1-Гарааны үнэлгээ; Д2-Барианы үнэлгээ*

Судалгааны асуулга, даалгаврын хариултын мэдээллийг Likert хэмжигдэхүүнээр хэмжсэн бөгөөд Д1.1-Д2.1 асуулга даалгаврыг 0-7 оноогоор, Д1.2-Д2.2, Д1.5-Д2.5, Д1.6-Д2.6 асуулга даалгаврыг 0-5 оноогоор, Д1.3-Д2.3, Д1.4-Д2.4 асуулга даалгаврыг 0-3 оноогоор оноожуулсан. Ийнхүү оноожуулснаар хэмжилтүүдийн статистик үр дүнг гаргах боломжтой болохоос гадна судалгаанд оролцогчдод асуулгад хариулж,

даалгавар гүйцэтгэхэд ойлгомжтой болсон.

- Шинэ ур чадвар ба судалгааны арга зүйд суралцсан байдал
- Суралцахуй ба багшийн үнэлгээ
- Судалгааны ёс зүй, арга зүйг эзэмшсэн байдал

## Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Энэхүү судалгаанд түүврийн ямарваа нэгэн аргачлал ашиглаагүй бөгөөд Багшийн сургуулийн нийт оюутнуудаас “Багш мэргэжлийн удиртгал”, “Хичээнгүй бичиг” хичээлийн сонголт хийсэн оюутнуудыг хамруулахыг зорьсон.

Хүснэгт 2. Судалгаанд ашигласан мэдээлэл

	Төлөвлөсөн оролцогчийн тоо	Судалгаанд ашигласан оролцогчийн тоо
Нийт	180	180 (100.00%)

## Өгөгдлийн шинжилгээ

Судалгааг гарааны (D1) болон барианы (D2) гэж хоёр үе шаттай авсан бөгөөд өгөгдлийн шинжилгээг MS-Excel, SPSS-27, Jamovi (үнэгүй) программ хангамж ашиглан хийсэн.

- Гарааны: “Багш мэргэжлийн удиртгал”, “Хичээнгүй бичиг” хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн өмнө
- Барианы: “Багш мэргэжлийн удиртгал”, “Хичээнгүй бичиг” хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараа

Судалгааны найдвартай байдлыг Cronbach alpha ( $\alpha$ ) шинжүүрээр хийж, гарааны (D1), барианы (D2) домайн тус бүрээр тооцсон болно. Судалгааны гол зорилго болох хөтөлбөр хэрэгжүүлсний өмнөх, дараах буюу гараа болон барианы үнэлгээнд статистик ач холбогдол бүхий ялгаа байгаа эсэхэд Paired samples t-test шинжилгээг хийлээ. Мөн кластер шинжилгээ хийж, судалгаанд оролцсон оюутнуудыг гүйцэтгэлээр нь ангилсан болно. Жич: Домайнуудын нийлбэр оноо ялгаатай тул гүйцэтгэлийн хувьд шилжүүлж, ижил хэмжээстэй болгосон болно.

## Судалгааны үр дүн

Даалгавар болон домайн тус бүрийн статистик үзүүлэлтийг хүснэгт 3-т үзүүлээ. Хүснэгт 3-аас харахад судалгааны ёс зүй, арга зүйг эзэмшсэн байдал хамгийн өндөр өсөлт 1.72 үзүүлсэн бол, багш нарын арга зүйг үнэлсэн үнэлгээ хамгийн бага буюу 0.11 байна.

Хүснэгт 3. Судалгааны даалгавруудын статистик үр дүн

Гараа	Дундаж1	Ст.Хаз1	Бариа	Дундаж2	Ст.Хаз2	Дунджийн зөрүү
D1.1.1	2.48	1.35	D2.1.1	3.28	1.32	0.80
D1.1.2	2.06	1.22	D2.1.2	2.69	1.14	0.63
D1.1	4.53	2.14	D2.1	5.97	1.96	1.43
D1.2.1	1.56	0.65	D2.2.1	1.98	0.62	0.42
D1.2.2	2.22	0.54	D2.2.2	2.33	0.55	0.11

Д1.2	3.78	0.97	Д2.2	4.31	0.89	0.53
Д1.3.1	1.74	1.07	Д2.3.1	2.54	1.03	0.80
Д1.3.2	1.94	0.95	Д2.3.2	2.87	0.77	0.92
Д1.3	3.68	1.84	Д2.3	5.41	1.57	1.72
Д1	11.99	3.74	Д2	15.68	3.34	3.69

### Найдвартай байдлын шинжилгээ


Домайн $\alpha$	Гарааны үнэлгээ	Барианы үнэлгээ
	0.677	0.620

Хэдийгээр Cronbach шинжүүрийн зөвшөөрөгдөх түвшин 0.7-оос дээш байдаг ч бид энэ удаа асуулга, даалгаврын тоо цөөн байгаа тул гарч ирсэн үзүүлэлтүүд хангалттай гэж үзлээ.

### Ялгаатай байдлын шинжилгээ

Бидний судалгааны гол зорилго болох өсөлт байгаа эсэхэд Paired Samples T-test шинжүүрээр шинжилгээ хийсэн үр дүнг хүснэгт 4-т үзүүллээ. Мөн зураг 1-т домайнуудын гүйцэтгэлийн хоорондын өсөлтийг харуулсан болно.

Зураг 1. Домайнуудын харьцуулсан зураглал (гүйцэтгэлийн хувиар)



Хүснэгт 4. Гараа болон барианы үнэлгээний ялгаа

Дунджуудын ялгаа	Ст.хазайлт	Ст.алдаа	t утга	
Д1.1.1 - Д2.1.1	-0.800	1.364	0.102	-7.872***
Д1.1.2 - Д2.1.2	-0.633	1.290	0.096	-6.588***
Д1.1 - Д2.1	-1.43333	2.14840	0.16013	-8.951***
Д1.2.1 - Д2.2.1	-0.422	0.784	0.058	-7.229***
Д1.2.2 - Д2.2.2	-0.111	0.587	0.044	-2.537*
Д1.2 - Д2.2	-0.53333	1.06441	0.07934	-6.722***
Д1.3.1 - Д2.3.1	-0.800	1.252	0.093	-8.569***
Д1.3.2 - Д2.3.2	-0.922	0.900	0.067	-13.751***
Д1.3 - Д2.3	-1.72222	1.87025	0.13940	-12.355***
Д1 - Д2	-3.689	3.715	0.277	-13.322***


\*\*\*P<0.001, \*\*P<0.01, \*P<0.05

Хүснэгт 4-өөс харахад гараа болон барианы үнэлгээний бүх асуулт, даалгавар, бүх домайн болон нийт онооны хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, тухайн хөтөлбөр хэрэгжснээр бүх үзүүлэлтүүд сайжирсан байна.

## Кластер шинжилгээ

Гарааны нийт оноо болон барианы нийт оноонд үндэслэн, кластер шинжилгээ хийв. Hierarchical кластер шинжилгээ хийж, кластерийн нийт боломжит тоог тогтооход гурав гэж гарсан бөгөөд K-means кластер шинжилгээг хийсэн.

Зураг 2. Кластеруудын дүрслэл (стандарт оноогоор)



Хүснэгт 5. Кластеруудын тоо/хувь

Кластер	Оюутны тоо	Хувь
Гараа барианы үнэлгээ дунджаас дээгүүр	49	27.22
Гараа үнэлгээ дунджаас доогуур барианы үнэлгээ дунджаас дээгүүр	41	22.78
Гараа барианы үнэлгээ дунджаас доогуур	90	50.00

Судалгаанд хамрагдсан оюутнуудын хүрээнд авч үзвэл, 27,22% нь хөтөлбөрийн явцад өөрийгөө хөгжүүлж чадахуйц сурах арга барил эзэмшсэн, 22,78% нь сургалтын шинэ арга зүйгээр дэмжиж, чиглүүлж чадвал ахиц дэвшлийг үзүүлдэг, 50% нь шинэ арга зүйгээр хичээллүүлсэн ч ахиц үзүүлж чадахгүй, сурах арга барил хангалттай түвшинд хүрч чадахгүй байгааг харуулж байна.

## Судалгаа №2

Оюутны бүтээлч даалгавар, бие даалтын удирдамжийг боловсруулахдаа “Суралцахуйн төлөвлөлт”, “Аяллын дараах судалгаа”, “Удирдамжтай ярилцлага”,

“Хошин зурган ppt”, “Багш, сурагчийн үйл ажиллагааны зураглал”, “Кейс+Зөвлөмж” зэрэг судалгааны аргыг хэрэглэсэн.

Нөхцөл байдлын судалгаанд үндэслэж, “Багш мэргэжлийн удиртгал”, “Хичээнгүй бичиг” хичээлийн хөтөлбөрт хамрагдсан оюутнуудад нийт 6 удаагийн судалгааны ажил өгч, тэдний хөгжлийг дэмжсэн болно. Тухайлбал:

- “Багш мэргэжлийн удиртгал” хичээл дээр багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, “Оюутан танд” сургалтын төлөвлөгөө, “Оюутны хөтөч” гарын авлага, хичээл сонголт зэргийг судалсан.
- Суралцахуйн төлөвлөлт гаргах, сургуулийн музейгээр аялсны дараа нэг үзмэр сонгож, түүнд холбогдох мэдээлэл цуглуулан, баримт нотолгоотой дүгнэлт бичсэн.
- “Хичээнгүй бичиг” хичээл дээр ЕБС-ийн багш нар болон оюутнуудын самбар, дэвтрийн бичлэгт ажиглалт хийж, шалгуурын дагуу тайлбар бичсэн.

### Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан оюутнуудын 80% нь судлаач оюутны ёс зүйн талаар мэдлэг, ойлголт дутмаг.
2. Бие даалт, бүтээлч даалгаврын удирдамжийг судалгаанд тулгуурласан байдлаар боловсруулан, арга зүйн дэмжлэг үзүүлэх нь оюутны судалгааны арга зүйн чадамжийг хөгжүүлдэг байна. Гарааны үнэлгээ хийхэд 19.4% нь судалгаа хийх арга барил эзэмшсэн байдлын хувьд 3 дугаар түвшинд байсан бол эцсийн үнэлгээгээр 53.9% 3 дугаар түвшин рүү шилжсэн байна. Энэ нь бие даалтын ажлаар дамжуулж, оюутны судалгаа хийх ур чадварыг хөгжүүлэх бүрэн боломжтойг харуулж байна.
3. Судалгаанд хамрагдсан оюутнуудын 50% хөтөлбөрийн явцад сурах арга барил эзэмших талаар идэвх санаачилга гаргаж, сурах үйлээ төлөвлөж, хэрэгжүүлэх буюу өөрийн удирдлагатай суралцах чадвар хангалтгүй байна. Энэ нь сургуулийн хөтөлбөрийн бодлогод оюутны суралцахуйд суралцах чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах шаардлага буйг харуулж байна.

### Ном зүй

1. Biggs, J. &. (2011). Train-the-trainers: implementing outcomes-based teaching and learning in Malaysian higher education. Scientific Reports, 1–19 .
2. Nadelson, L. S. (2017). (Nadelson) Integrated STEM defined: contexts, challenges, and the future. Scientific Reports, 221-223.
3. Grafstein, A. (2002). A Discipline-based approach to information literacy. The Journal of Academic Librarianship, 28(4), 197-204.
4. Winter, J., Cotton, D., Gavin, J. & Yorke, J.D. (2010). Effective e-learning? Multi-tasking, distractions and boundary management by graduate students in an online environment. ALT-J, Research in Learning Technology, 18(1), 71-83, doi:10.1080/09687761003657598.

## **OPPORTUNITIES TO SUPPORT STUDENT LEARNING THROUGH RESEARCH-BASED CREATIVE ASSIGNMENTS (Example of Second-Year Students at the Teachers' School)**

<sup>a</sup>Ganbold D., <sup>b</sup>Bulgan B.  
<sup>a</sup>Ph.D., Teachers School, MNUE;  
<sup>b</sup>Ph.D., Teachers School, MNUE

Corresponding author: ganbold.d@msue.edu.mn 

### **Abstract**

This study explores the learning and teaching assessments of students enrolled in teacher education programs, with a particular focus on their engagement with research methodology and their ability to process information. A total of 180 students from the School of Education at the Mongolian National University of Education (MNUE), who were taking the courses “Introduction to the Teaching Profession” and “Penmanship”, participated in the study.

The findings reveal that research-based independent assignments play a significant role in enhancing students' learning capabilities and information processing skills. A variety of research-oriented methods were incorporated into the design of creative and independent tasks, including Learning Planning, Post-Trip Research, Guided Interviews, Comic-Style Presentations, Teacher–Student Activity Mapping, and Case Analysis with Recommendations. These approaches have been shown to effectively support students in developing metacognitive strategies for learning and in critically engaging with information.

The study underscores the importance of integrating research-based tasks in pre-service teacher education to foster both academic competence and practical teaching readiness.

### **Keywords**

Learning to learn; Information processing; Research methodology; Research-based learning; Innovative teaching strategies; Self-directed learning; Student engagement; Teacher education

---